ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Орхон аймгийн Аравдугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2026/024/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Эрдэнэт хот<br>2026 он | Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва<br>Утас: 70353088 Цахим хаяг: : purevlkhagvap@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Буян-Ундрах<br>Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn<br><br>Аудитор: О.Гантуяа<br>Утас: 70355805 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.........................................................................
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ............................5
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ...................................................................
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа........................................................................
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....................... **Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал............. **Error! Bookmark not defined.**
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .**Error! Bookmark not defined.**
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ......... **Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН ..................................................... **Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл ......................................................... **Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал............................................... **Error! Bookmark not defined.**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт........ **Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....**Error! Bookmark not defined.**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .................. **Error! Bookmark not defined.**
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ...........................................................................................10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин |

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026. 02. 15 № 50
танай ____________-ны № ____________-т

ОРХОН АЙМГИЙН АРАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Т.ЭНХМАА
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон Аравдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Аравдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Орхон аймгийн болзошгүй аваарын зардлаар хийгдсэн 229,101.8 мянган төгрөгийн цонх, дээврийн засвар, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 275,396.0 мянган төгрөгийн сангийн засварын ажлыг цэцэрлэгийн барилгад капиталжуулан бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Боловсролын салбарын байгууллагууд 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 14 хоногийн ажил хаялтад нэгдэж, Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 30.3-т “Ажил хаялтад оролцоогүй боловч түүнээс шалтгаалан ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй байсан ажилтанд тухайн хугацаанд дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг ажил олгогч олгоно” гэж заасны дагуу цалин хөлсөө авсан байна.

61250530 7

**Бусад асуудал**

Цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээнд 10 багш үнэлэгдсэн ба байгууллага гүйцэтгэлийн индексийн 4 дүгээр түвшинд 95.5% үнэлэгдэж, байгууллага 7,311.5 мянган төгрөгөөр шагнуулсан.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 160 хүүхдээр тооцсон ч 145 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 113,635,253.01 | 47,358,724.29 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 113,635,253.01 | 47,358,724.29 |
| 3121 | Төгрөг | 113,635,253.01 | 47,358,724.29 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 113,635,253.01 | 47,358,724.29 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 62,073,190.00 | 64,173,190.00 |
| 351 | Түүхий эд материал | 60,081,360.00 | 62,181,360.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 60,081,360.00 | 62,181,360.00 |
| 354 | Хангамжийн материал | 1,991,830.00 | 1,991,830.00 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 305,300.00 | 305,300.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 1,686,530.00 | 1,686,530.00 |
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 175,708,443.01 | 111,531,914.29 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,593,740,673.54 | 2,046,003,914.37 |
| 392 | Биет хөрөнгө | 1,331,300,673.54 | 1,783,563,914.37 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,371,072,218.77 | 1,875,570,020.77 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -173,686,811.56 | -214,751,170.48 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 130,238,730.30 | 127,370,054.30 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -40,881,811.06 | -58,762,726.44 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 44,199,940.00 | 59,543,840.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -19,237,683.51 | -24,471,590.38 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 162,557,782.06 | 162,557,782.06 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -142,961,691.46 | -143,492,295.46 |
| 393 | Биет бус хөрөнгө | 262,440,000.00 | 262,440,000.00 |
| 39301 | Програм хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -400,000.00 | -400,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 262,440,000.00 | 262,440,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,593,740,673.54 | 2,046,003,914.37 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,769,449,116.55 | 2,157,535,828.66 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,769,449,116.55 | 2,157,535,828.66 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 531,065,752.54 | 531,065,752.54 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 139,615,092.81 | 527,701,804.92 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 139,615,092.81 | 139,615,092.81 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 388,086,712.11 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,098,768,271.20 | 1,098,768,271.20 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,769,449,116.55 | 2,157,535,828.66 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,769,449,116.55 | 2,157,535,828.66 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 798,833,000.00 | 972,264,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 742,709,600.00 | 921,754,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 742,709,600.00 | 921,754,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 56,123,400.00 | 50,510,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,123,400.00 | 50,510,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 255,590,731.00 | 628,601,909.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 255,590,731.00 | 628,601,909.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 58,880,918.00 | 92,342,407.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 58,880,918.00 | 92,342,407.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 163,834,453.00 | 526,397,802.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 32,875,360.00 | 9,861,700.00 |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,054,423,731.00 | 1,600,866,409.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 971,517,506.36 | 1,210,101,468.01 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 966,002,886.45 | 1,200,176,851.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 655,661,210.63 | 874,261,881.03 |
| 210101 | Үндсэн цалин | 434,717,986.15 | 516,334,672.80 |
| 210102 | Нэмэгдэл | 195,441,010.68 | 298,087,074.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 6,112,200.00 |
| 210104 | Урамшуулал | 25,502,213.80 | 53,727,934.05 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 67,623,915.48 | 105,917,609.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,726,807.66 | 72,106,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,954,638.67 | 8,292,018.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,193,918.89 | 4,320,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,159,009.49 | 4,250,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,589,540.77 | 16,948,790.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,274,780.09 | 30,585,583.47 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,254,598.18 | 7,361,156.97 |
| 210302 | Түлш, халаалт | 16,216,263.07 | 16,379,595.37 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,803,918.84 | 6,844,831.13 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,502,350.00 | 9,861,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,346,000.00 | 4,501,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,411,500.00 | 5,360,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 13,744,850.00 | |
| 2105 | Нормативт зардал | 61,305,230.00 | 56,663,825.00 |
| 210502 | Хоол, хүнс | 61,305,230.00 | 56,663,825.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,334,000.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,334,000.00 | 10,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,110,000.00 | 1,440,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,110,000.00 | 1,440,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,191,400.25 | 111,446,252.29 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,899,832.00 | 33,666,720.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,408,400.00 | 6,323,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 66,883,168.25 | 71,456,332.29 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,514,619.91 | 9,924,616.53 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 5,514,619.91 | 9,924,616.53 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,514,619.91 | 9,924,616.53 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 971,517,506.36 | 1,210,101,468.01 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 82,906,224.64 | 390,764,940.99 |

| | | | |
|---|---|---|---|
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 2,678,228.88 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 2,678,228.88 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -2,678,228.88 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 82,906,224.64 | 388,086,712.11 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 857,713,918.00 | 1,064,606,907.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 58,880,918.00 | 92,342,407.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 58,880,918.00 | 92,342,407.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 58,880,918.00 | 92,342,407.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 58,880,918.00 | 92,342,407.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 798,833,000.00 | 972,264,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 742,709,600.00 | 921,754,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 742,709,600.00 | 921,754,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 56,123,400.00 | 50,510,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,123,400.00 | 50,510,200.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 887,163,988.11 | 1,130,883,435.72 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 887,163,988.11 | 1,130,883,435.72 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 881,649,368.20 | 1,120,958,819.19 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 655,661,210.63 | 874,033,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 433,760,436.15 | 515,982,429.80 |
| 210102 | Нэмэгдэл | 196,398,560.68 | 298,211,336.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 6,112,200.00 |
| 210104 | Урамшуулал | 25,502,213.80 | 53,727,934.05 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 67,623,915.48 | 106,145,590.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,726,807.66 | 72,106,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,954,638.67 | 8,520,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,193,918.89 | 4,320,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,159,009.49 | 4,250,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,589,540.77 | 16,948,790.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,274,780.09 | 30,585,583.47 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,663,071.18 | 7,361,156.97 |
| 210302 | Түлш, халаалт | 16,807,790.07 | 16,379,595.37 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,803,918.84 | 6,844,831.13 |
| 2105 | Нормативт зардал | 61,305,230.00 | 56,663,825.00 |
| 210502 | Хоол, хүнс | 61,305,230.00 | 56,663,825.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,334,000.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,334,000.00 | 10,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,110,000.00 | 1,440,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,110,000.00 | 1,440,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,340,232.00 | 42,089,920.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,931,832.00 | 35,766,720.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,408,400.00 | 6,323,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,514,619.91 | 9,924,616.53 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 5,514,619.91 | 9,924,616.53 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,514,619.91 | 9,924,616.53 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | -29,450,070.11 | -66,276,528.72 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -29,450,070.11 | -66,276,528.72 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 113,635,253.01 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 47,358,724.29 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 531,065,752.54 | 1,098,768,271.20 | 139,615,092.81 | 1,769,449,116.55 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 531,065,752.54 | 1,098,768,271.20 | 139,615,092.81 | 1,769,449,116.55 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 531,065,752.54 | 1,098,768,271.20 | 139,615,092.81 | 1,769,449,116.55 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 388,086,712.11 | 388,086,712.11 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 531,065,752.54 | 1,098,768,271.20 | 527,701,804.92 | 2,157,535,828.66 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 979,624,800.00 | 972,264,500.00 | 7,360,300.00 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 929,114,600.00 | 921,754,300.00 | 7,360,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 929,114,600.00 | 921,754,300.00 | 7,360,300.00 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 50,510,200.00 | 50,510,200.00 | 0.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 50,510,200.00 | 50,510,200.00 | 0.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 176,288,800.00 | 92,342,407.00 | 83,946,393.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 176,288,800.00 | 92,342,407.00 | 83,946,393.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,155,913,600.00 | 1,064,606,907.00 | 91,306,693.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,155,913,600.00 | 1,130,883,435.72 | 25,030,164.28 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,155,913,600.00 | 1,120,958,819.19 | 34,954,780.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 898,497,100.00 | 874,033,900.00 | 24,463,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 546,118,300.00 | 515,982,429.80 | 30,135,870.20 |
| 210102 | Нэмэгдэл | 327,201,700.00 | 298,211,336.15 | 28,990,363.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,112,200.00 | -6,112,200.00 |
| 210104 | Урамшуулал | 25,177,100.00 | 53,727,934.05 | -28,550,834.05 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 111,584,500.00 | 106,145,590.72 | 5,438,909.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 75,705,600.00 | 72,106,200.00 | 3,599,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,969,800.00 | 8,520,000.00 | 449,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,484,800.00 | 4,320,300.00 | 164,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,484,800.00 | 4,250,300.00 | 234,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,939,500.00 | 16,948,790.72 | 990,709.28 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 40,510,200.00 | 30,585,583.47 | 9,924,616.53 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,212,200.00 | 7,361,156.97 | 851,043.03 |
| 210302 | Түлш, халаалт | 24,048,000.00 | 16,379,595.37 | 7,668,404.63 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,250,000.00 | 6,844,831.13 | 1,405,168.87 |
| 2105 | Нормативт зардал | 79,783,000.00 | 56,663,825.00 | 23,119,175.00 |
| 210502 | Хоол, хүнс | 79,783,000.00 | 56,663,825.00 | 23,119,175.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,000,000.00 | 10,000,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | 0.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | 0.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,422,500.00 | 1,440,000.00 | 1,982,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,422,500.00 | 1,440,000.00 | 1,982,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,116,300.00 | 42,089,920.00 | -29,973,620.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,793,100.00 | 35,766,720.00 | -29,973,620.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,323,200.00 | 6,323,200.00 | 0.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 9,924,616.53 | -9,924,616.53 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох | | 9,924,616.53 | -9,924,616.53 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 9,924,616.53 | -9,924,616.53 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | | 1,130,883,435.72 | -1,130,883,435.72 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 113,635,253.01 | -113,635,253.01 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 47,358,724.29 | -47,358,724.29 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,117.5 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 4,117.5 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд: Үр дүнгийн тайланд 2,678.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсны гарзыг зардлаар бүртгэсэн, 2025 оны 12 дугаар сарын 31-ний гүйлгээ 1,439.3 мянган төгрөгийн зардлыг дутуу бүртгэснийг тус тус залруулав.

Аудитаар нийт 15,230.8 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 420.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,642.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,167.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч байна.

### 5.1 Төлбөрийн акт

Албан томилолтоор ажилласан албан хаагчид 420.0 мянган төгрөгийн нөхөн олговор илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 13,642.9 мянган төгрөгийг албан хаагчдад орон нутгийн төсвөөс олгодог орон нутгийн нэмэгдэл цалингийн зардалд зарцуулсан, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроосон, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийг мэдээлээгүй зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлж байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Бараа материалын данстай холбоотой**

*<u>Илрүүлэлт</u>:*

Цэцэрлэгийн хүүхдийн ирцийг, хоолны зарцуулалттай тулгахад тогтоосон нормоос 379.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно",13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолын 1-т “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3000 (гурван мянга) төгрөгөөр, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4100 (дөрвөн мянга нэг зуун) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай” гэж заасантай нийцэхгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:**

Хүүхдийн хоолны зардлыг тогтоосон нормын дагуу олгож байх.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт*</u>:

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах биеийн тамирын багшийн ажлыг хавсруулж 623.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагааг явуулахыг хориглоно”, 12.1-т “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>***Өгсөн зөвлөмж***</u>:

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалыг хавсруулан ажиллуулахгүй байх.

## 2. Зардлын ангилалтай холбоотой асуудал.

<u>*Илрүүлэлт:*</u>

Мэдээлэл технологийн зардлаас 165.0 мянган төгрөгийн компьютерын хэрэгсэл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтын зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>***Өгсөн зөвлөмж:***</u>

Мэдээлэл технологийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аудитаар нийт 4,117.5 мянган төгрөгийн алдаа[3] илэрснээс аудитын явцад 4,117.5 мянган төгрөгийн алдааг залруулав. | 2 | 4,117.5 | 1 | 1,439.3 | 1 | 2,7678.2 | 2 | 4,117.5 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан томилолтоор ажилласан албан хаагчид 420.0 мянган төгрөгийн нөхөн олговор илүү олгосон. | 1 | 420.0 | 1 | 420.0 | | | | | | | | |
| Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 13,642.9 мянган төгрөгийг албан хаагчдад орон нутгийн төсвөөс олгодог орон нутгийн нэмэгдэл цалингийн зардалд зарцуулсан байна. | 1 | 13,642.9 | | | 1 | 13,642.9 | | | | | . | |
| Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроосон, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийг мэдээлээгүй. | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |

[3] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цэцэрлэгийн хүүхдийн ирцийг, хоолны зарцуулалттай тулгахад тогтоосон нормоос 379.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. | 1 | 379.3 | | | | | 1 | 379.3 | | | | |
| Арга зүйчид шууд харьяалан удирдуулах биеийн тамирын багшийн ажлыг хавсруулж 623.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна. | 1 | 623.6 | | | | | 1 | 623.6 | | | | |
| Мэдээлэл технологийн зардлаас 165.0 мянган төгрөгийн ухаалаг хулгана худалдан авсан байна. | 1 | 165.0 | | | | | 1 | 165.0 | | | | |
| **Дүн** | **6** | **15,230.8** | **1** | **420.0** | **2** | **13,642.9** | **3** | **1,167.9** | | | | |